



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/110

Хэрлэн сум

Төлөвлөгөө баталж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын наймдугаар хуралдааны 2021 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.3.2-д заасан "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" арга хэмжээг зохион байгуулах зардалд зориулж 10 000 000 (арван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, төсвийн тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа), гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж. Ганбаатар) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010308

03 Аймгийн Засаг даргын 2022 оны
 ... дүгээр сарын ... өдрийн ... А/110
 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



"БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙН ХҮРЭЭНД БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	Сумдад Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн цахим сан "e-khutuch.mn" буланд төрийн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор мэдээлэл оруулах	2022 оны 1-4 дүгээр улиралд	Бүх сумд, тосгонд, "e-khutuch.mn" сайтад 80 хувь мэдээлэлтэй болсон байна.	ХЭЗХ	ХЗҮХ, СЗДТГ
2	Иргэдэд эрх зүйн боловсрол, хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг танхимаар мэдээлэл хүргэх арга замаар иргэдэд түгээх	Улирал бүр	Жилд 10 мянган иргэн, аж ахуйн нэгжийн ажилчид, төрийн албан хаагчдад хууль тогтоомжийн мэдлэгийг дээшилсэн байна	ХЭЗХ	ЦГ, НД, ЭМГ, МХГ, Татвар, ГХБХБГ
3	Эрх зүйн хөтчөөр бэлтгэсэн хөтөч ажилтнуудад давтан сургалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах	2022 оны 2, 3 дугаар улиралд	Хөтөч нар 2-оос доошгүй удаа зохион байгуулагдсан байна.		ХЗҮХ
4	Иргэдэд зориулсан эрх зүйн гарын авлага, боршур, шторк хийх, сумдад хүргүүлэх	Жилдээ	Улиралд 1 шторк, боршур хүргэгдсэн байна.	ХЭЗХ	ХЗҮХ
5	Албан байгууллага сургалт авах санал ирүүлсэн байгууллагад сургалт хийх	Жилдээ	Төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн боловсрол мэдлэг дээшилсэн байна.		ХЭЗХ

Аймгийн Засаг даргын 2022 оны
 03 дүгээр сарын 01 өдрийн 01/10
 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



**"БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙН
 ХҮРЭЭНД БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСВИЙН ТООЦОО**

№	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Санхүүжүүлэх эх үүсвэр /сая төгрөг/	Хариуцах байгууллага
1	Сумдад Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн цахим сан "e-khutuch.mn"буланд төрийн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор мэдээлэл оруулах	2022 оны 1-4 дүгээр улиралд	Бүх сумд, тосгонд, "e-khutuch.mn" сайтад мэдээтэй болсон байна.	1.500.000	ХЗҮХ, ХЭЗХ, СЗДТГ
2	Иргэдэд эрх зүйн боловсрол, хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг танхимаар мэдээлэл хүргэх арга замаар иргэдэд түгээх	Улирал бүр	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	6.500.000	ХЭЗХ
3	Эрх зүйн хөтчөөр бэлтгэсэн хөтөч ажилтнуудад давтан сургалт зохион байгуулах (цахим)	1 удаа	Хөтөч нар иргэдэд сургалт зохион байгуулах эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	-	ХЭЗХ
4	Иргэдэд зориулсан эрх зүйн гарын авлага, боршур, шторк хийх, сумдад хүргүүлэх	2022 оны 1 дүгээр улиралд	Иргэдийн хууль, эрх зүйн боловсрол мэдлэг дээшилсэн байна.	2.000.000	ХЭЗХ
5	Албан байгууллага сургалт авах санал ирүүлсэн байгууллагад сургалт хийх	Жилдээ	Төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн боловсрол мэдлэг дээшилсэн байна.	-	
Нийт				10 000 000	